



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ”
ТӨААТҮГ-ЫН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахь хаягаар харилцана уу:

САГазрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885
Цахим хаяг:
gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Сэржмядаг
Утас: 261740
Цахим хаяг:
serjmyadag@audit.gov.mn

[Монгол Улсын](#)
[Үндэсний аудитын газар:](#)
Засгийн газрын IY байр
Улаанбаатар-15160
Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг
Вэб хуудас: www.audit.mn

[“Йуаууеуе-Аоаеө” ӨӨЁ](#)
БГД, 18-р хороо,
Sky apartment, 4 давхар, 19 тоот
ᠴᠢᠪᠡᠳᠡᠭᠡ: ᠠ.ᠣᠶᠢᠶᠠᠭᠠᠳᠡ
ᠣᠳᠠᠶᠢ: 70159511
Вэб хуудас:
medeeleaudit@gmail.com

АУДИТЫН ТАЙЛАН

АГУУЛГА

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Аудитын тайлан

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

*Хавсралт 5: Зорилтот түвшингийн биелэлтийн
мэдээ*

Хавсралт 6: “Зам, тээврийн хөгжлийн төв”

ТӨААТҮГ-ын санхүүгийн тайлан, тодруулга

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

1	Аудитын гэрчилгээ.....	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	3
2.5	Дотоод хяналт.....	3
2.6	Зорилтот түвшний биелэлтийн талаарх тайлбар, тодруулга	4
2.7	Шилэн дансны мэдээлэл	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	4
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	5
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	6
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	6
2.14	Материаллаг байдлын суурь СОНГОСОН үндэслэл, тайлбар:.....	6
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	6
3	Менежментийн захидал.....	7
	Эздийн өмч	9
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	11
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.5	Зорилтот түвшний биелэлт.....	14



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.15 № 06/722
танай _____ -ны № _____ -т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Р.БУД ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0315SAG54.Docx

01


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Үүрэг, хариуцлага

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0315SAG54.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын захирал Р.Буд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, зардлыг төсөвлөх, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн тайлагнах, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ-2018/63/СТА-ТӨҮГ аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн байгууллагын санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай



нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 23-наас 3 дугаар сарын 12-ны хооронд хийхээр төлөвлөн, “Мэдээлэл Аудит” ХХК-ийн ахлах аудитор Д.Товуудоржоор удирдуулсан аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 02 дугаар сарын 09-ний өдөр “Мэдээлэл-Аудит” ХХК –д ирүүлсэн.

“Мэдээлэл-Аудит” ХХК нь “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 23-наас 3 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдөр “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлагад гардуулна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин


“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ нь үйл ажиллагааны дараах чиглэлтэй байна. Үүнд:

- Авто замын салбарын эрдэм шинжилгээ, судалгааг хөгжүүлэх, олон улсын жишигт хүргэн, салбарын сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудын хөгжлийн хандлагыг тодорхойлох, эрдэм шинжилгээ судалгааг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх,
- Салбарын норм норматив, стандартын тогтолцоог боловсронгуй болгох, олон улсын жишигт ойртуулах,
- Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын чанар, аюулгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх,
- Авто замын санд олон улсын болон улсын чанартай авто замаар зорчсон төлбөр хураах үйл ажиллагааг боловсронгуй болгох зэрэг хамаарна.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлага нь:

Хууль:

- Иргэний хууль
- Компаний тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Авто замын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай багц хууль
- Татварын тухай багц хууль
- Аудитын тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Иргэний хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хууль



Дүрэм журам:

- МУ-ын ЗГ-ын 68-р тогтоол “Босго үнэ батлах тухай”
- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журам”
- Сангийн сайдын 2013 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 77 дугаар тушаал “Маягт заавар батлах тухай”
- “Татварын тайлан гаргах, татварын албанд тайлан хүлээн авах журам”
- “Татварын өрийн үлдэгдэлд торгууль, алданги тооцох ногдуулах журам”
- “Сангийн сайдын тушаал журам батлах тухай” 2010 оны 121-р тушаал “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам” зэрэг хууль эрх зүйн орчны хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 15-г хийж гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оноос мөрдөж байгаа санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь СТОУС-тай нийцсэн байна. “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь төрийн аудитын байгууллага турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

2.6 Зорилтот түвшний биелэлтийн талаарх тайлбар, тодруулга

2017 оны батлагдсан зорилтот түвшингийн төлөвлөгөөг сар, улирлын хуваарийн дагуу төлөвлөгөөний гүйцэтгэлийг ханган ажилласан байна.

Зорилтот түвшингийн тодотгосон төлөвлөгөөгөөр 1,173.5 сая төгрөгийн орлоготой, 1,705.4 сая төгрөгийн зардалтай, 531.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн хэдий ч 1,760.4 сая төгрөгийн орлоготой ажиллаж орлогын төлөвлөгөөг 150 хувиар давуулан биелүүлсэн байна.

Нийт зардлыг 1,705.4 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 98 хувиар буюу 1,668.1 сая төгрөгийг зарцуулж, татварын өмнөх ашгийг 100 хувиар биелүүлсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 5, 6, 7 дугаар зүйл, Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор төсвийн болон улс орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, удирдлагын шийдвэр үйл ажиллагаа ил тод, нээлттэй ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэн ажиллаж байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 148 мэдээлэл байршуулахаас 148 мэдээлэл байршуулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 14 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 15 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна:

1. “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын конторын өргөтгөлийн барилгын ажлын зургийн төслийн төлбөрт төлсөн 8.1 сая төгрөгийг үйл ажиллагааны бус зардалд бүртгэн үр дүнгээ буруу тайлагнасан, урьчилж төлсөн тооцоо дансанд бүртгээгүй стандарт зөрчсөн, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-ийн “Дараахь зардлыг албан татвар ногдох орлогоос хасч тооцсоны үндсэн дээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно” гэсэн заалтыг мөрдөөгүй.

Шийдвэрлэсэн: “Аудитаар илэрсэн асуудлын бүртгэл”-ийн дагуу зөрчлийг шийдвэрлэн Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2. Төлбөр хураах цэгт ТӨБЗГазрын 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 241 дугаар тогтоолоор 237.7 сая төгрөгийн анхны үнэтэй 186.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 51.5 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй тээврийн хэрэгслийг шилжүүлсэн байна. Тээврийн хэрэгслийн үлдэгдэл өртөгийг “Орлогын дэлгэрэнгүй тайлан”-д ҮХ данснаас хассаны гарзаар бүртгэн үйл ажиллагааны үр дүнг буруу илэрхийлсэн, Төрийн өмчийн хэмжээг өөрчлөөгүй байгаа нь Хуулийн

этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиудийг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: “Аудитаар илэрсэн асуудлын бүртгэл”-ийн дагуу зөрчлийг шийдвэрлэн Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

3. Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй 6.3 сая төгрөгийн зардлыг үйл ажиллагааны зардлаар, мөн үйл ажиллагааны бус 8.6 сая төгрөгийн зардлыг үзүүлсэн ажил үйлчилгээний өртөг / 6020 / дансанд тус тус бүртгэсэн нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-ийн “Дараахь зардлыг албан татвар ногдох орлогоос хасч тооцсоны үндсэн дээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно” гэсэн заалт зөрчигдөх, Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэн, татварын эрсдэл үүссэн байна.

Шийдвэрлэсэн: “Аудитаар илэрсэн асуудлын бүртгэл”-ийн дагуу зөрчлийг шийдвэрлэн Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 29 дүгээр тушаалын дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны удирдах ажилтануудын гадаадад томилолтоор ажилласан 7.9 сая төгрөгийг санхүүжүүлсэн нь ТӨБЗГ-ын 2017 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 365 дугаар тогтоолоор батлагдсан ЗТХТ-ийн зорилтот түвшинд тусгагдаагүй, үр ашиггүй зардал гаргасан байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2017 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 365 дугаар “ЗТХТ-ийн төлөвлөгөөг өөрчлөн батлах тухай” тогтоолыг мөрдөөгүй, Төсвийн тухай хуулийн 6.4.1-ийн “**төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах**” гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх.

2. Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрийн хөрөнгийн хэмжээ 2,047.5 сая төгрөг, Санхүүгийн тайланд Төрийн өмчийн хэмжээ 1,064.3 сая төгрөг байгаа нь 983.2 сая төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Хуулийн этгээдийн хувийн хэрэг дараах мэдээллийг агуулна”, 11.3-т “...11.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол тухайн хуулийн этгээд ажлын 15-ны өдрийн дотор энэ талаар улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ” гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

“Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 364 дугаар тогтоолоор баталсан Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны тодотгосон төлөвлөгөө нь 531.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар байгаа нь анхаарал татахуйц байна.



2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгөнд биет тест хэрэгжүүлээгүй, эрсдэлтэй байж болох асуудлыг 2018 оны завсрын аудитаар шалгахар тогтов.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 82.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг аудитын явцад 74.5 сая төгрөгийн зөрчлийг залруулан, 7.9 сая төгрөг нь Зам, тээврийн хөгжлийн яамтай холбоотой байсан нь санхүүгийн тайланд материаллаг нөлөөгүй байсан.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-т 2016 оны санхүүгийн тайланд “Ворлдвайд фاینэнс аудит” ХХК-иар 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, 100 хувь биелэсэн байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Материаллаг байдлын суурийг орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 1,740.4 сая төгрөгийн 1 хувь буюу 17,4 сая төгрөгөөр төлөвлөлтийн үед авч байсан. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг манай аудитын багийн гишүүд зөвшилцөн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын гүйцэтгэл 1,668.1 сая төгрөгийн 1 хувь буюу 16.7 сая төгрөг болгон өөрчлөлт оруулсан.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ



“Зам, тээврийн хөгжлийн төв”
ТӨААТҮГ-ЫН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Эздийн өмчийн талаар

10



Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Эздийн өмч

Тэргүүлэх ач холбогдол №2

Аудитын ажиглалт

Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрийн хөрөнгийн хэмжээ 2,047.5 сая төгрөг, Санхүүгийн тайланд Төрийн өмчийн хэмжээ 1,064.3 сая төгрөг байгаа нь 983.2 сая төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Хуулийн этгээдийн хувийн хэрэг дараах мэдээллийг агуулна”, 11.3-т “...11.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол тухайн хуулийн этгээд ажлын 15-ны өдрийн дотор энэ талаар улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ” гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

Аудитын зөвлөмж

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Хуулийн этгээдийн хувийн хэрэг- дараах мэдээллийг агуулна”, 11.3-т “...11.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор энэ талаар улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ” гэж заасныг мөрдөн ажиллахыг зөвлөж байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 05 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль зөрчигдөх, Санхүүгийн тайлангийн хэмжил, Эрх ба үүрэг, Толилуулга ба илчлэл гэсэн батламж мэдэгдлүүд хангагдахгүй байх, Санхүүгийн тайлан, мэдээ мэдээлэл буруу илэрхийлэгдэх,

Үйлчлүүлэгчийн хариу

Дээрх зөрчилд зөвлөмж өгснийг холбогдох байгууллага хүлээн зөвшөөрч 2018 оны 04 дүгээр сарын 30-ны дотор багтаан хэрэгжүүлэх хариу ирүүлсэн.



4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	821,320,837.57	1,219,701,418.03
Дансны авлага	72,680,112.00	54,085,368.28
Татвар, НДШ-н авлага		
Бусад авлага		
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал	122,844,395.10	123,665,444.85
Урдчилж төлсөн зардал/тооцоо		12,060,000.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,016,845,344.67	1,409,512,231.16
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	2,026,554,505.66	2,795,418,585.58
Биет бус хөрөнгө	2,447,000.07	2,067,900.07
Биологийн хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,029,001,505.73	2,797,486,485.65
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,045,846,850.40	4,206,998,716.81
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	584,744.75	
Цалингийн өглөг		
Татварын өр	110,754.00	10,719,829.77
Богино хугацаат өр төлбөрийн дүн	695,498.75	10,719,829.77
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл		
Бусад урт хугацаат өр төлбөр		
Хойшлогдсон орлого		1,118,063,314.62
Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	1,118,063,314.62
Өр төлбөрийн нийт дүн	695,498.75	1,128,783,144.39
Эздийн өмч		
Өмч : - төрийн	1,064,339,806.08	1,012,811,105.36
- хувийн		
- хувьцаат		
Халаасны хувьцаа		
Эздийн өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг	1,980,811,545.57	2,065,404,467.06
Эздийн өмчийн дүн	3,045,151,351.65	3,078,215,572.42
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,045,846,850.40	4,206,998,716.81

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	1,834,593,122.43	1,737,647,877.37
Борлуулалтын өртөг		1,621,856,708.04
Нийт ашиг (алдагдал)	1,834,593,122.43	115,791,169.33
Түрээсийн орлого		
Хүүний орлого	5,847,447.57	22,779,952.65
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого	1,869,470.00	
Борлуулалт, маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	1,934,529,712.54	31,372,825.00
Санхүүгийн зардал		
Бусад зардал	32,805,254.65	14,847,702.00
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(39,632,000.01)	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
Бусад ашиг (алдагдал)		
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(164,656,927.20)	92,350,594.98
Орлогын татварын зардал	584,744.75	10,719,829.77
Татварын дараах ашиг (алдагдал)	(165,241,671.95)	81,630,765.21
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(165,241,671.95)	81,630,765.21
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
Цэвэр ашиг /алдагдал/	(165,241,671.95)	81,630,765.21



4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,061,770,008.08			2,146,053,217.52	3,207,823,225.60
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	1,061,770,008.08	-	-	2,146,053,217.52	3,207,823,225.60
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(165,241,671.95)	(165,241,671.95)
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт	2,569,798.00				2,569,798.00
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,064,339,806.08	-	-	1,980,811,545.57	3,045,151,351.65
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				2,962,156.28	2,962,156.28
Залруулсан үлдэгдэл	1,064,339,806.08	-	-	1,983,773,701.85	3,048,113,507.93
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				81,630,765.21	81,630,765.21
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт	(51,528,700.72)				(51,528,700.72)
Зарласан ногдол ашиг					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,012,811,105.36	-	-	2,065,404,467.06	3,078,215,572.42



4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	2,387,097,822.0	1,904,381,532.0
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,199,561,126.96	1,695,013,131.04
Буцаан авсан албан татвар		
Бусад мөнгөн орлого	187,536,695.00	209,368,401.00
Мөнгөн зарлагын дүн (-)	1,743,657,396.79	1,507,488,484.23
Ажиллагчдад төлсөн	1,051,716,841.19	781,938,431.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	225,954,859.06	170,500,992.20
Бараа материал худалдан авахад төлсөн	38,412,953.00	72,472,984.00
Ашиглалтын зардалд төлсөн	22,519,413.00	23,744,894.33
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	29,605,164.00	65,327,084.30
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	97,583,771.24	73,943,418.40
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага	277,864,395.30	319,560,680.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	643,440,425.17	396,893,047.81
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	1,869,470.00	22,779,952.65
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	1,869,470.00	
Хүлээн авсан хүүгийн орлого		22,779,952.65
Хүлээн авсан ногдол ашиг		
Мөнгөн зарлагын дүн (-)	10,251,580.00	21,292,420.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	10,251,580.00	9,232,420.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		12,060,000.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(8,382,110.00)	1,487,532.65
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	-
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Төлсөн ногдол ашиг		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	635,058,315.17	398,380,580.46
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	186,262,522.38	821,320,837.57
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	821,320,837.57	1,219,701,418.03

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗОРЧИЛТИЙН


САНАЛ ДҮГНЭЛТ

4.5 Аудит хийгдсэн зорилтот түвшний биелэлт

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Жилийн өссөн дүн		Өөрчлөлт	
			2017 оны тодотгосон төлөвлөгөө /2017.09.12/	гүйцэтгэл	2017 оны тодотгосон төлөвлөгөөнөөс	хувь
1	Авто замын барилгын ажлын техник, технологийн хяналт	мян.төг	393,491.5	445,920.2	52,428.7	113%
2	АЗЗА компаниудын техник, технологийн хяналт	мян.төг	148,178.0	382,847.8	234,669.8	258%
3	Лабораторийн сорил шинжилгээний ажил, тоног төхөөрөмжийн түрээс, замын чанар, байдлын судалгаа, дүгнэлт	мян.төг	182,000.0	212,978.8	30,978.8	117%
4	Техник ашиглалтын түвшин тогтоох ажил	мян.төг	150,000.0	192,785.5	42,785.5	129%
5	Хөдөлгөөний эрчмийн судалгаа	мян.төг	60,000.0	117,184.5	57,184.5	195%
6	Эрдэм шинжилгээ судалгаа, стандарт, норм дүрэм боловсруулах	мян.төг	33,000.0	9,861.2	- 23,138.9	30%
7	Зураг төсөл төсвийн экспертизийн үйл ажиллагаа	мян.төг	150,000.0	279,736.5	129,736.5	186%
8	ТХЦэгээс ЗХЗ, бусад орлого	мян.төг	56,880.0	119,113.3	62,233.3	209%
	НИЙТ ОРЛОГЫН ДҮН		1,173,549.5	1,760,427.8	586,878.3	150%
1	Үндсэн цалин	мян.төг	736,364.4	690,305.2	- 46,059.2	94%
2	Нэмэгдэл	мян.төг	100,058.0	85,859.1	- 14,198.9	86%
3	Унаа хоол	мян.төг	69,191.0	49,171.5	- 20,019.5	71%
4	НДШ	мян.төг	100,288.5	91,926.5	- 8,362.0	92%
	Нийт цалингийн зардал		1,005,901.9	917,262.3	- 88,639.6	91%
1	Бичиг хэргийн зардал	мян.төг	7,488.4	7,442.2	- 46.2	99%
2	Халаалт, дулаан	мян.төг	5,630.0	3,708.8	- 1,921.2	66%
3	Цахилгааны зардал	мян.төг	7,750.0	5,622.6	- 2,127.4	73%
4	Хог хаягдлын зардал	мян.төг	3,768.0	3,466.8	- 301.2	92%
5	Шатахууны зардал	мян.төг	50,013.8	63,547.2	13,533.4	127%
6	Шуудан, холбооны зардал	мян.төг	5,774.4	6,836.9	1,062.5	118%
7	Дотоод албан томилолт	мян.төг	65,807.9	61,402.5	- 4,405.4	93%
8	Гадаад албан томилолт	мян.төг	18,000.0	17,906.2	- 93.8	99%
9	Зар сурталчилгааны зардал	мян.төг	12,000.0	11,820.1	- 179.9	99%
10	Хөдөлмөр хамгааллын зардал	мян.төг	9,321.2	5,705.8	- 3,615.4	61%
11	Аж ахуй, дотоод хэрэгцээний зардал	мян.төг	8,844.0	8,723.9	- 120.1	99%
12	Урсгал засвар, сэлбэгийн зардал	мян.төг	22,760.0	22,539.6	- 220.4	99%
13	Төлбөр хураамжийн зардал	мян.төг	7,200.0	6,108.9	- 1,091.1	85%
14	Түрээсийн зардал	мян.төг	7,000.0	15,810.7	8,810.7	226%
15	Сургалт семинарын зардал	мян.төг	18,500.0	10,540.9	- 7,959.1	57%
16	Нэг удаагийн тэтгэмж, шагналын зардал	мян.төг	16,000.0	15,975.3	- 24.7	100%



17	Ахмад настан, баяр ёслол, спортын арга хэмжээний зардал	мян.төг	18,720.0	10,154.6	-	8,565.4	54%
18	Газрын төлбөр	мян.төг	590.1	526.3	-	63.8	89%
19	Автомашинтай холбогдон гарах татвар, даатгал	мян.төг	4,440.0	2,909.0	-	1,531.0	66%
20	Төсөл арга хэмжээ үйл ажиллагааны бус бусад зардал	мян.төг	144,000.0	119,527.9	-	24,472.1	83%
21	Аудитын зардал	мян.төг	7,000.0	2,500.0	-	4,500.0	36%
22	Элэгдлийн зардал	мян.төг	258,900.0	348,038.6	-	89,138.6	134%
	Цалингаас бусад зардлын дүн		699,507.8	750,814.9		51,307.2	107%
	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		1,705,409.7	1,668,077.2	-	37,332.4	98%
	ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ, АЛДАГДАЛ		- 531,860.2	92,350.6		624,210.7	544%
	Орлогын албан татвар	мян.төг		10,719.8		9,021.6	
	ТАТВАРЫН ДАРААХ АШИГ, АЛДАГДАЛ		- 531,860.2	81,630.8		615,189.1	
	Хөрөнгө оруулалт	мян.төг	10,000.0	9,232.4	-	767.6	92%

